

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

- 1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт
- 1.2 Хот, хөдөөгийн хүн амын харьцаа
- 1.3 Нийт өрхийн тоо, нэг өрхөд ногдох хүн
- 1.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц

БҮЛЭГ 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

- 2.1 Төрөлт
- 2.2 Нас баралт
- 2.3 Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт

БҮЛЭГ 3. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

- 3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал
- 3.2 Шилжин ирэлт
- 3.3 Шилжин явалт
- 3.4 Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн


БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт

Өвөрхангай аймгийн хүн амын тоо 2018 оны жилийн эцсийн байдлаар 116.6 мянга болж, өмнөх оныхоос 961 мянган хүн буюу 0.8 хувиар өссөн бол 2005 оныхоос 7.4 мян.хүн буюу 6.7 хувиар, 2008 оныхоос 5.2 мян.хүн буюу 4.7 хувиар тус тус өссөн байна. Хүн амын тоо 2005 оноос хойш өссөн хэдий ч өсөлтийн хурд тогтвортой байсангүй. Тухайлбал, хүн амын өсөлтийн хурд 2007-2009 хүртэл аажим өсч байснаа 2010 онд эргэн саарч, 2012 оноос өсч 2017 онд жилийн дундаж өсөлт 1.5, 2018 онд 0.8 өссөн байна.

ЗУРАГ 1.1. ХҮН АМЫН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ 2005-2018 ОН




Хүн амын өсөлтөд төрөлт, нас баралт, гадаад шилжих хөдөлгөөн гэсэн хүн ам зүйн үндсэн гурван үзүүлэлт шууд нөлөөлдөг.

Сумдын хүн амын өсөлт, бууралтад хүн амын ердийн өсөлтөөс илүү механик өсөлтийн нөлөөлөл их хэвээр байна. Аймгийн төв болон УБ хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал их байгаа нь аймаг нийслэлийн хүн ам жил ирэх тусам хурдтай өсөх нөхцөлийг үүсгэж байна.

Аймгийн нийт хүн амын 49.7 хувь нь эрэгтэйчүүд, 50.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 98.9 байна.

ЗУРАГ 1.2. ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮН АМЫН ХУВИЙН ЖИН 2018 ОН



1.2 Хот, хөдөөгийн хүн амын харьцаа


2018 оны эцсийн байдлаар Аймгийн нийт нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 52.0 хувь буюу 60.6 мянга нь сумын төвд амьдарч байгаагийн дотор Бат-Өлзий, Уянга, Хужирт, Хархорин, Арвайхээр зэрэг сумдын хүн амын 59-ээс дээш хувь нь сумын төвд оршин сууж байна. Харин бусад сумдын хүн амын 41-ээс дээш хувь нь хөдөөд амьдарч байна. 2009-2018 онд дунджаар, нийт хүн амын 55.2 хувь нь сумын төвд амьдарч байна.

ХҮСНЭГТ 1.1. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, СУМААР 2014-2018 ОН

	2013		2014		2015		2016		2017		2018	
	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө
Бүгд	61319	50505	65013	47578	63264	49510	16716	16824	64310	51374	60627	56018
Баян - Өндөр	1188	2747	1089	2782	1045	2773	317	842	749	3067	1049	2675
Бүрд	614	2325	854	1989	750	2117	143	704	767	2184	469	2482
Бат - Өлзий	4718	2369	4634	2567	3871	3363	818	1375	4374	3125	2851	4746
ББ- Улаан	701	1925	1096	1563	1094	1628	262	457	963	1840	777	2036
Баянгол	712	3143	954	2853	926	2896	201	957	1018	2921	672	3273
Гүчин - Ус	940	1243	761	1399	889	1272	144	479	676	1519	485	1724
Есөнзүйл	859	2290	978	2094	775	2248	229	680	916	2199	745	2289
Өлзийт	425	2006	625	1866	625	1830	216	524	1002	1444	751	1723
ЗБ - Улаан	745	3206	1225	2780	1242	2703	199	1062	823	3243	922	3106
Богд	921	4370	1205	4151	1060	4314	247	1200	1583	4043	807	4847
Нарийнтгээл	931	2634	1005	2563	1247	2301	407	618	831	2832	1127	2541
Сант	1136	2339	1194	2500	913	2638	191	841	781	2863	666	2942
Тарагт	981	2133	1186	1994	1195	2025	396	691	806	2567	1187	2151
Төгрөг	1150	1562	1020	1650	1158	1493	240	580	1126	1638	769	1994
Уянга	2861	6145	4230	5104	4044	5385	852	1963	5020	4492	2815	6800
Хайрхандулаан	1300	2038	1289	2052	1330	2027	233	873	888	2630	712	2809
Хужирт	3379	3234	3442	3094	3182	3448	856	1094	3609	3142	2866	991
Хархорин	9250	3319	9878	2665	9439	2826	2638	1147	8958	3558	8610	3889
Арвайхээр	28508	1477	28348	1912	28479	2223	8127	737	29420	2067	32347	-

Сүүлийн жилүүдийн хот, хөдөөгийн хүн амын өсөлтийн чиг хандлагыг харахад нийт дүнд эзлэх сумын төвийн хүн амын хувийн жин нэмэгдэж, хөдөөгийн хүн амын хувийн жин буурах төлөвтэй байна. Сумын төвийн өрх өсч байгаа нь аймгийн дотоод шилжих хөдөлгөөний урсгал гол төлөв төв, суурин газар руу чиглэж байгаатай холбоотой юм. Нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 2018 онд 1.8 болсон байна.

ЗУРАГ 1.3. ХҮН АМЫН НЯГТРАЛ, СУМААР, 2018 ОН



Сумаар авч үзвэл Арвайхээр сум нь нийт нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг хэрнээ хүн амын нягтралаар хамгийн өндөрт орж байна. 2018 оны байдлаар Арвайхээр сумын нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 185 хүн ногдож байгаа нь өмнөх оныхоос 3 хүнээр нэмэгджээ. Бусад сумдын хүн амын нягтралыг харахад газар нутгийн хэмжээ, хүн амын тооноосоо шалтгаалан харилцан адилгүй, тухайлбал Хархорин, Хужирт, Уянга, Бат-Өлзий зэрэг сумдууд бусдаас хамгийн өндөр, Баруунбаян-Улаан, Төгрөг, Богд, Гучин-Ус, Хайрхандулаан зэрэг сумдууд хамгийн бага буюу нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт нэг хүрэхгүй хүн ногдож байна. Энэ нь мөн л хүн амын дотоод шилжих хөдөлгөөний урсгал төврүү чиглэсэн байгааг илэрхийлж байна.

1.3 Нийт өрхийн тоо, нэг өрхөд ногдох хүн

2018 онд нийт өрхийн тоо 34.6 мянга болж 2017 оныхоос 1.5 хувиар өссөн байна. Нийт өрхийн 24.7 хувь нь сумын төвд, 48.1 хувь нь хөдөөд амьдарч байна. Бат-Өлзий, Уянга, Хужирт, Хархорин, Арвайхээр зэрэг сумдын сумын төвийн өрх нь хөдөөгийн өрхүүдээс илүү байхад бусад сумдуудын хөдөөгийн өрх нь сумын төвийн өрхүүдээс их байна.

Аймгийн дунджаар нэг өрхөд 3.4 хүн ногдож байгаа бөгөөд нэг өрхөд ногдох хүний тоогоор ББУлаан, Богд, Сант, Арвайхээр зэрэг сумдууд аймгийн дунджаас өндөр буюу 3.5-3.9 хүн ногдож байгаа юм. (Хүснэгт 1.2).

ХҮСНЭГТ 1.2. ӨРХИЙН ТОО БОЛОН НЭГ ӨРХӨД НОГДОХ ХҮНИЙ ТОО, СУМААР 2013-2018 ОН


	2013	2014	2015	2016	2017	2018	1 өрхийн дундаж ам бүл
Бүгд	32421	33015	33275	33540	34150	34652	3.4
Баян - Өндөр	1180	1169	1166	1159	1169	1165	3.3
Бүрд	816	811	832	847	858	860	3.4
Бат - Өлзий	2169	2174	2186	2193	2229	2275	3.4
ББ- Улаан	686	697	711	719	718	716	3.9
Баянгол	1114	1109	1128	1158	1174	1176	3.3
Гүчин - Ус	589	596	609	623	637	647	3.4
Есөнзүйл	907	900	914	909	929	934	3.3
Өлзийт	724	735	736	740	766	767	3.2
ЗБ - Улаан	1188	1123	1238	1261	1302	1321	3.1
Богд	1398	1412	1433	1447	1484	1507	3.8
Нарийнтээл	984	1031	1024	1025	1060	1061	3.4
Сант	1001	1042	1023	1032	1041	1052	3.5
Тарагт	994	1017	1050	1087	1094	1090	3.1
Төгрөг	797	793	798	820	824	826	3.3
Уянга	2657	2810	2828	2815	2834	2871	3.3
Хайрхандулаан	1032	1052	1068	1106	1114	1114	3.1
Хужирт	1920	1957	1937	1950	1992	2006	3.4
Хархорин	3625	3729	3754	3785	3828	3869	3.3
Арвайхээр	8640	8858	8840	8864	9097	9395	3.5

1.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн амын насны бүтцийг судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Ингэснээрээ хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшингээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран үе үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг. Тухайлбал, үйлдвэр уурхай, барилга, хөдөө аж ахуйн зэрэг салбарт ажиллах хүн хүчний нөөц хэр зэрэг байх, сургууль, эмнэлэг, үйлчилгээний байгууллагын хүчин чадал байршил ямар байх зэрэг нь хүн амын насны бүтцээс хамаарч зохицуулагддаг билээ. Нөгөө талаар хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний чиг хандлага ч насны бүтцээс хамааралтай байдаг. Тухайлбал, хүн амын насны бүтэц идэрших хандлагатай болоход (хүн амд хөдөлмөрийн насны хүний эзлэх хувь нэмэгдэх үйл явц) цаашид хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүний онцлогийг харгалзан ямар төрлийн ажлын байрыг илүү хэрэгцээтэй болохыг тохируулах шаардлага гарна

ЗУРАГ 1.4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, 2015-2018 ОН



2018 оны нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл 30.9 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 64,6 хувийг 15-64 насны хүн ам, 4.4 хувийг 65 ба түүнээс дээш насны өндөр настнууд эзэлж байна. Сүүлийн жилүүдэд хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буурч, өндөр настны эзлэх хувь өсч байгааг дээрх графикаас харж болно.

Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлдөг. Хүн ам зүйн цонх нээгдсэн үед хүүхэд, залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт удаан хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалт болон ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц байх нөхцөл бүрэлдсэн гэж ойлгож болох юм.

ХҮСНЭГТ 1.3. ХҮН АМЫН ТОО, ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, СУМААР, 2018 ОН

Сумын нэр	Хүн амын тоо	Хүн ам зүйн ачаалал	Хүйсийн харьцаа
Бүгд	116645	54.6	98.9
Баян - Өндөр	3724	54.6	101.0
Бүрд	2951	56.1	104.9
Бат - Өлзий	7597	55.5	99.0
ББ- Улаан	2813	57.6	100.2
Баянгол	3945	48.0	100.2
Гүчин - Ус	2209	51.1	99.7
Есөнзүйл	3034	56.4	106.3
Өлзийт	2474	56.7	103.2
ЗБ - Улаан	4028	51.2	107.5
Богд	5654	57.4	102.0
Нарийнтээл	3668	48.9	102.6
Сант	3608	51.5	103.1
Тарагт	3338	48.2	106.1
Төгрөг	2763	52.1	103.0
Уянга	9615	52.8	99.9
Хайрхандулаан	3521	49.4	104.1
Хужирт	6857	56.8	102.2
Хархорин	12499	54.7	99.5
Арвайхээр	32347	57.6	91.7


Өвөрхангай аймгийн хүн ам зүйн ачаалал 2018 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 54,6 хүн ногдож байна. Амьдралд энэ үзүүлэлт тооцооноос нэлээд илүү байдаг. Тухайлбал, хөдөлмөрийн насанд байгаа үедээ 15-24 насныхан ихэнх нь боловсролоо ахиулах, мэргэжил эзэмшихээр суралцаж тэжээлгэгч байдаг. Мөн хөдөлмөрийн насанд байгаа боловч жирэмсэн, бага насны хүүхэд, өндөр настанг асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй, ажиллах чадваргүй, эсвэл ажилгүйчүүд гэх мэт тэжээлгэгчдийн тоо өсдөг.

2018 онд хөдөлмөрийн насны хүн ам ихэнх хувийг эзэлж байгаа учир хүн ам зүйн ачаалал нилээд буурсан байна.

Сумдуудын хүн амын хүйсийн харьцааг харвал Баян-Өндөр, Бат-Өлзий, Хархорин, Арвайхээр зэрэг сумдад 100 эмэгтэйд 91-99 эрэгтэй ногдож байна. Бусад сумдад 100 эмэгтэйд 99-с дээш эрэгтэй ногдож байна.

Хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж байна. 2017 онд 0-4 насны хүн амын тоо 5-9 насны хүн амын тооноос их, харин 10-14 насны хүн амын тоо бага байгаа нь 2002-2006 оны төрөлт бага байсныг харуулж байна.

ЗУРАГ 1.5. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2018 ОН




2006 оноос эхлэн төрөлт нэмэгдэж эхэлсэн нь суваргаас харагдаж байна. Түүнчлэн 20-29 насны хүн ам харьцангуй их, ерөнхийдөө хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонхны үе үргэлжлэхийг суварга харуулж байна.

БҮЛЭГ 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

Сүүлийн 10 гаруй жилийн хүн амын цэвэр өсөлт нь аймгийн хүн амын өсөлтөд нөлөө үзүүлсэн юм. Төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК) 1990 оноос хойш эрчимтэй буурах хандлага ажиглагдаж 2004 онд 20.0, 2005 онд 19.4 болж буурч байсан хэдий ч 2006-2009 онд тогтмол өсч 2017 онд 21.6 болсон 2018 онд 22.8 болж буурсан байна. Нас баралтын ерөнхий коэффициент 2018 он 6.4 болжээ.

ЗУРАГ 2.1. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЦЭВЭР ӨСӨЛТ 1000 ХҮНД НОГДОХООР, 2006-2017 ОН



2.1 Төрөлт

1990 оноос хойшхи хүн амын төрөлтийн эрчимтэй бууралтанд нийгэм, эдийн засгийн шилжилтийн байдал, 1989 оны сүүлчээр үр хөндөлтийг чөлөөтэй болгосон, эмэгтэйчүүд жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийг хэрэглэж төрөлтөө зохицуулах болсон, гэрлэлтийн нас хойшилсон, цөөхөн ам бүлтэй байх сонирхолтой болсон, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшилсэн зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн юм. Гэсэн хэдий ч 2006 оноос эхлэн төрөлтийн түвшин нэмэгдэж эхэлсэн нь 18 нас хүртэлх хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ төрсөн хүүхэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой.

ЗУРАГ 2.2. ТӨРӨЛТИЙН ТОО, СҮҮЛИЙН 10 ЖИЛД ХАМГИЙН ИХ БАГА ОНООР



Төрөлтийн түвшин 2006-2009 онд нэмэгдэж, 1000 хүнд ногдох төрөлт 2009 онд 26.5 хүрч байснаа 2014 оноос буурах хандлагаруу орж, 2017 онд 21.6 болж өмнөх оныхоос 2.0 пунктээр буурсан 2018 онд 22.8 болж өмнөх оныхоос 1.2 пунктээр өссөн байна. Төрсөн хүүхдийн тоо 2018 онд 2662 болж 2017 оныхоос 6.4 хувиар буурсан байна. Аймгийн төрөлтийн тоог сүүлийн 10 жилээр харвал 2009 онд хамгийн өндөр төрөлттэй, 2007 онд хамгийн бага төрөлтийн түвшинтэй байна.

Төрөлтийн тоог сумдаар харвал Арвайхээр сумын төрөлт бусад сумдаас их байгаа нь нийт төрөлтийн түвшний 30.0 хувийг эзэлж байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 70.0 хувь нь хөдөөд төрсөн байна.

ХҮСНЭГТ 2.1. ТӨРСӨН ХҮҮХЭД, ХҮЙСЭЭР, СУМААР

Сумдууд	Төрсөн хүүхэд		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	2662	1363	1299
Баян - Өндөр	71	44	27
Бүрд	69	34	35
Бат - Өлзий	194	99	95
ББ- Улаан	69	29	40
Баянгол	84	44	40
Гүчин - Ус	44	22	22
Есөнзүйл	57	32	25
Өлзийт	57	27	30
ЗБ - Улаан	68	36	32
Богд	162	78	84
Нарийнтээл	84	49	35
Сант	63	32	31
Тарагт	74	43	31
Төгрөг	59	35	24
Уянга	228	116	112
Хайрхандулаан	66	29	37
Хужирт	192	90	102
Хархорин	225	118	107
Арвайхээр	796	406	390

2.2 Нас баралт

Хүн амын нас баралтын түвшин 2012 онд 1000 хүнд ногдох нас баралт 6.8, 2013 онд 6.2, 2014 онд 6.8 болж өсч байсан бол 2015 онд 6.3, 2016 онд 5.8 болж буурчээ. Энэ үзүүлэлт 2017 онд 6.0 болж өмнөх оныхоос 0.2 пунктээр өссөн 2018 онд 6.4 болж өмнөх оныхоос 0.4 пунктээр өссөн байна. Сүүлийн 10 жилээр нас баралтын түвшинг харьцуулбал 201 онд хамгийн их буюу 751 хүрчээ.

ЗУРАГ 2.4. НАС БАРАЛТЫН ТОО , сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



Нас барсан хүний тоог сумаар үзвэл Бат-Өлзий, Уянга, Хужирт, Хархорин, Арвайхээр сумдад хамгийн их байна. Мөн нас барсан хүний 27.8 хувь нь аймгийн төвд, 72.2 хувь нь хөдөө сумдад нас баржээ. Нас баралтын хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн нас баралтын тоог харвал аймгийн дундаж 157 байгаа нь эрэгтэйчүүд илүү нас барж байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна.

ХҮСНЭГТ 2.2. НАС БАРСАН ХҮН, ХҮЙСЭЭР, СУМААР

Сумдууд	Нас баралт		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	753	442	311
Баян - Өндөр	27	18	9
Бүрд	17	11	6
Бат - Өлзий	35	17	18
ББ- Улаан	18	12	6
Баянгол	29	21	8
Гүчин - Ус	7	4	3
Есөнзүйл	22	13	9
Өлзийт	14	7	7
ЗБ - Улаан	27	16	11
Богд	42	26	16
Нарийнтээл	18	13	5
Сант	24	16	8
Тарагт	28	17	11
Төгрөг	13	6	7
Уянга	71	48	23
Хайрхандулаан	18	11	7
Хужирт	56	28	28
Хархорин	77	43	34
Арвайхээр	210	115	95

2.3 Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт


Нийт 561 хос 2018 онд гэрлэлтээ бүртгүүлж, 78 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 58 хүүхэд үрчлэгджээ. Гэрлэлт өмнөх оныхоос 16.0 хувиар, үрчлэлт 10.3 хувиар өсч, гэр бүл цуцлалт 1.8 хувиар буурсан байна. 1000 хүнд ногдох гэрлэлт 2012 онд 1.5, 2013 онд 2.3, 2014 онд 3.5, 2015 онд 4.7, 2016 онд 4.1, 2017 онд 4.6 болж өмнөх оныхоос 0.5 пунктээр нэмэгдсэн 2018 онд 4.8 болж өмнөх оныхоос 0.2 пунктээр нэмэгдсэн байна. Гэр бүл цуцлалт 2013 онд 0.9, 2014 онд 0.6, 2015 онд 0.6, 2016 онд 0.5, 2017 онд 0.5 2018 онд 0.6 байна. Гэрлэлтийн тоо нь 2006 онд хамгийн өндөр түвшинд буюу 2450-д хүрч байжээ.

ЗУРАГ 2.5. ГЭРЛЭЛТИЙН ТОО , сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



1000 хүн амд ногдох гэрлэлт 2004 оноос өсөх хандлагатай болсон ба 2006 оноос эхлэн “Шинэ гэр бүл бологчид” хөтөлбөрийн хүрээнд шинээр гэр бүл бологчдод нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгож эхэлсэнтэй холбоотойгоор гэрлэлт нэмэгдэж 2006 онд 2450-д хүрсэн хэдий ч 2007-2012 онуудад тасралтгүй буурч байсан бол 2013 оноос өссөн байна.

ЗУРАГ 2.6. 1000 ХҮНД НОГДОХ ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, 2008-2017 ОН



ЗУРАГ 2.7. ЦУЦЛАЛТЫН ТОО, сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



2018 онд 58 хүүхэд үрчлэгдсэний 48.0 хувь нь 3 хүртэлх насны, 34.7 хувь нь 3-6 насны, 8.0 хувь нь 7-9 насны, үлдсэн 9.3 хувь нь 10 ба түүнээс дээш насны хүүхдүүд байна.

ХҮСНЭГТ 2.3. ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТ, НАСНЫ БҮЛГЭЭР, СУМААР 2018 ОН

Сумын нэр	Бүгд	Хүүхдийн насны бүлэг			
		3 хүртэлх настай	3-6 настай	7-9 настай	10, түүнээс дээш настай
дҮН	58				
Áàÿí-áíá°ð					
Á¿ðä					
Áàò-°èçèé	5				
ÁÁ-Óèààí	3				
Áàÿíáíè	1				
Áó-èí-Óñ	1				
Áñ°íç¿éè	2				
°èçèéò	1				
ÇÁ-Óèààí	2				
Áíää	2				
Íàðèéíóÿýè	2				
Ñàíò	1				
Òàðààò	1				
Ò°ãð°ã	1				
Óÿíää	2				
Õàéððàíáóèààí	1				
Õóæèðò	4				
Õàððíðèí	6				
Àðààéóÿýð	23				

БҮЛЭГ 3. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн амын шилжих хөдөлгөөн нь төрөлт, нас баралтын нэг адил хүн амын өсөлт, өөрчлөлтийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уугуул нутгийн хүн амын өөрчлөлтийг газар зүйн нэгжүүдээр тодорхойлж, хүн амын хөдөлгөөнийг судалдаг. Хүн амын зарим хөдөлгөөн нь түр зуурын байх буюу уугуул нутаг нь өөрчлөгдөхгүй байх тохиолдлыг шилжих хөдөлгөөнд тооцдоггүй. Иймд шилжих хөдөлгөөн нь тусгайлан тогтоосон засаг захиргааны болон газар зүйн нэгжүүдийн хооронд, түүнчлэн газар нутгийн байршлын /хот, хөдөө/ хувьд явагдах хүн амын суурьшлын өөрчлөлт юм.


Монгол Улсын “Иргэний бүртгэлийн тухай” хуулийн 25 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан журамд “Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээсээ нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухыг түр шилжин суурьших гэнэ” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсад хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудлыг Үндсэн хууль, Иргэний бүртгэлийн тухай, Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хууль, түүнчлэн Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам” зэрэг хууль тогтоомжоор зохицуулдаг. Дээрх эрх зүйн актуудаар хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулдаг ч аймагт шилжин суурьшигчдын нэлээд хэсэг нь журмын дагуу шилжиж суурьшаагүй, байнгын оршин суугчийн зөвшөөрөл, албан ёсны бүртгэлгүй хүмүүс байгаа юм.

3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал

2018 оны жилийн эцэст 855 хүн шилжин ирж, 1140 хүн шилжин явсан байна. Нийт шилжин ирсэн хүн амын 473 хүн буюу 55.3 хувь нь аймгийн төвд шилжин ирсэн байна. Мөн Бат-Өлзий суманд 37 хүн, Богд суманд 24, Хужирт суманд 31 хүн, Хархорин суманд 85 хүн шилжиж очсон байна. Шилжиж явсан хүн амын байдлаас харахад Хархорин сумаас 85, Арвайхээр сумаас 681, Богд сумаас 53 хүн, Уянга сумаас 42 хүн, Баруунбаян-Улаан сумаас 31 хүн явсан нь бусад сумдаас өндөр байна.


ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, 2006-2018 ОН



3.2 Шилжин ирэлт

2018 оны жилийн эцсийн байдлаар нийт шилжин ирэгчдийн 60.5 хувь нь УБ хотоос, 39.4 хувь нь бусад аймгаас шилжин ирсэн байна. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин ирэлтийн коэффициент юм.

ЗУРАГ 3.2. ШИЛЖИН ИРЭЛТИЙН КОЭФФИЦИЕНТ, 2006-2018 ОН



Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо бөгөөд 2006 онд 7.9, 2007 онд 5.3, 2008 онд 5.6, 2009 онд 4.9, 2010 онд 6.2, 2011 онд 3.3 болж буурсан бол 2012 онд 5.2, 2013 онд 7.1 болж өсчээ. 2014 онд 6.7, 2015 онд 7.5, 2016 онд 9.6, 2017 онд 9.3 болж, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 пунктээр буурсан 2018 онд 7.3 болж өмнө оныхоос 2.0 пунктээр буурсан байна. (Зураг 3.2).

ХҮСНЭГТ 3.1. ШИЛЖИН ИРЭГЧИД, СУМААР 2007-2018 ОН


Сумын нэр	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	576	624	553	698	373	579	793	760	849	1095	1078	855
Баян - Өндөр			18	5	2	7	12	14	29	32	37	9
Бүрд	14	14	19	30	4	1	24	22	22	43	42	24
Бат - Өлзий	20	98	27	31	19	9	66	25	30	221	41	37
ББ- Улаан	11	5	17	3	2		7	7	6	27	15	7
Баянгол	7	4	3	4	1	2	7	4	23	20	16	32
Гүчин - Ус	1	8	9	2	1	8	3	8	19	7	11	13
Есөнзүйл	37	15	12		7	8	20	22	16	17	42	6
Өлзийт	10	15	7	13	3	12	13	8	17	9	16	7
ЗБ - Улаан	5	5	15	5	5	3	7	4	17	29	10	7
Богд	6	4	7	13	6	3	16	19	19	25	38	34
Нарийнтээл	7	7	20	24	5	9	13	24	20	19	32	12
Сант	44	15	10	26	2	5	4	6	12	15	23	22
Тарагт			4	9	11	3	4	6	22	17	16	8
Төгрөг	5	7	3	4	1	3	1	4	7	26	38	10
Уянга	62	42	30	31	20	9	13	34	43	45	31	29
Хайрхандулаан	7	7	15	12	9	2	7	10	21	5	13	9
Хужирт	51	69	23	66	23	23	36	37	20	34	60	31
Хархорин	56	111	52	131	39	52	222	153	122	138	208	85
Арвайхээр	233	198	262	289	213	420	318	353	384	366	389	473

3.3 Шилжин явалт

2018 оны жилийн эцэст 1140 хүн байнга оршин суудаг засаг захиргааныхаа нэгжээс шилжин явсан байна. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин явалтын коэффициент юм. Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжин явагчдын тоо бөгөөд 2017 оны эцэст 1000 хүн тутмын 8 нь байнга оршин сууж байсан засаг захиргааны нэгжээсээ шилжин явсан нь 2007

оныхоос 11.2 пунктээр, 2010 оныхоос 12.6 пунктээр, 2012 оныхоос 9.8 пунктээр, 2013 оныхоос 22.8 пунктээр, 2014 оныхоос 19.6 пунктээр, 2016 оныхоос 12.4 пунктээр буурсан 2017 оныхоос 0.8 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 3.3 ШИЛЖИН ЯВАЛТЫН КОЭФФИЦИЕНТ, 2006-2018 ОН



ХҮСНЭГТ 3.2. ШИЛЖИН ЯВАГЧИД, СУМААР, 2007-2017 ОН


Сумын нэр	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	2103	1378	1725	2309	3307	1974	3441	3108	2639	2362	968	1140
Баян - Өндөр	-	-	77	83	151	81	199	143	132	143	68	18
Бүрд	33	92	86	78	78	41	165	173	62	56	27	28
Бат - Өлзий	66	38	49	90	64	22	82	84	72	246	53	18
ББ- Улаан	23	26	38	23	40	29	47	41	43	15	18	31
Баянгол	1	3	6	10	32	61	44	22	80	48	26	17
Гүчин - Ус	17	21	26	64	18	22	67	30	41	18	6	11
Есөнзүйл	26	78	67	-	112	72	159	114	115	74	24	24
Өлзийт	36	35	44	53	85	30	82	72	71	37	15	4
ЗБ - Улаан	23	48	26	68	45	31	60	54	53	23	24	20
Богд	40	70	42	77	62	46	71	62	78	54	12	53
Нарийнтээл	31	31	33	73	40	37	99	89	55	77	22	17
Сант	105	35	70	105	98	65	98	135	88	67	37	15
Тарагт	5	12	58	5	52	10	52	28	57	5	7	16
Төгрөг	10	28	20	11	61	11	41	51	39	32	17	20
Уянга	38	63	87	107	102	147	183	204	162	104	36	42
Хайрхандулаан	18	21	34	50	44	41	48	60	49	29	12	11
Хужирт	123	141	136	161	197	115	231	238	94	118	60	29
Хархорин	834	38	214	271	359	247	646	526	467	389	169	85
Арвайхээр	674	598	612	980	1667	866	1067	982	881	827	335	681

Нийт шилжин явагчдын 59.7 хувь нь Арвайхээр, 17.4 хувь нь Хархорин, 7.4 хувь нь Уянга, 3.6 хувь нь Богд 4.6 сумаас шилжин явагчид эзэлж байна. (Хүснэгт 3.2).

3.4 Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн

Шилжих хөдөлгөөний гол үзүүлэлт болох цэвэр шилжих хөдөлгөөний талаар энэ бүлэгт авч үзлээ. Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент (ШХЦК) нь шилжин ирэлт болон шилжин явалтын коэффициентуудын ялгавраар илэрхийлэгдэнэ. ШХЦК нь 2006 онд -2.8 байсан бол 2013 онд -23.7, 2014 онд -20.9, 2015 онд -15.9, 2016 онд -11.1, 2017 онд 1.0, 2018 онд -2.4 болсон байна.

ЗУРАГ 3.4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЦЭВЭР КОЭФФИЦИЕНТ, 2006-2018 ОН



Дотоод шилжих хөдөлгөөний хувьд ШХЦК нь 0 гарах ёстой байдаг хэдий ч иргэний бүртгэлийн явцад хугацааны зөрүүтэй байдлаас шалтгаалан энэ үзүүлэлт 0 гарах нь ховор байдаг. Эндээс үзэхэд 2018 онд шилжин явалт нь шилжин ирсэнээс их байгаа нь 2018 онд Улаанбаатар хотруу шилжих хөдөлгөөнийг хязгаарлалтгүй болсонтой холбоотой гэж үзэж байна.

БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

Аймгийн хүн амын тоо 2018 оны жилийн эцсийн байдлаар 116.6 мянга болж, өмнөх оныхоос 961 мянган хүн буюу 0.8 хувиар өслөө. Хүн амын 49.7 хувь нь эрэгтэйчүүд, 50.3 хувь нь эмэгтэйчүүд юм. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 99 байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар 34.6 мянган өрх, түүний 24.7 хувь нь сумын төвд, 48.2 хувь нь хөдөөд байгаа бөгөөд аймгийн дунджаар нэг өрхөд 3.4 хүн ногдож байна.

Төрсөн хүүхдийн тоо 2018 онд 2662-д хүрч өмнөх оныхоос 6.4 хувиар буурсан байна. Аймгийн хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 99 хөвгүүн ногдож байна. Энэ онд 1000 хүнд ногдох нас баралт 6.4 болж, өмнөх оныхоос 0.4 пунктээр өсчээ.

Нийт 561 хос 2018 онд гэрлэлтээ бүртгүүлж, 78 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 58 хүүхдийг үрчилж авчээ. **Гэрлэлт өмнөх оныхоос 16.0 хувиар, үрчлэлт 10.3 хувиар өсч, гэр бүл цуцлалт 1.8 хувиар буурсан байна.** 1000 хүнд ногдох гэрлэлт 2010 онд огцом буурч, 22.2-оос 2.7 болсон бол 2013 онд 2.3, 2014 онд 3.5, 2015 онд 4.7, 2016 онд 4.1, 2017 онд 4.6, 2018 онд 4.8 болж өмнөх оныхоос 0.2 пунктээр нэмэгдсэн байна байна. Гэр бүл цуцлалт 2018 онд 0.6 болж өмнөх оныхоос 0.1 пунктээр өссөн байна. Гэрлэлтийн тоо 2006 онд хамгийн их буюу 2450-д хүрч байсан бөгөөд энэ нь тэр үеийн шинэ гэр бүлд мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой нэмэгдэж байсан билээ.

2018 оны жилийн эцэст 855 хүн шилжин ирж, 1140 хүн шилжин явсан байна. 1000 хүнд ногдох шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо 2012 онд 5.2, 2013 онд 7.1 болж өсчээ. 2014 онд 6.7, 2015 онд 7.5, 2016 онд 9.6, 2017 онд 9.3 болж, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 пунктээр буурсан 2018 онд 7.3 болж өмнө оныхоос 2.0 пунктээр буурсан байна. Нийт шилжин ирсэн хүн амын 473 хүн буюу 55.3 хувь нь аймгийн төвд шилжин ирсэн байна. 1000 хүнд ногдох шилжин явагчдын тоо 2007 оныхоос 11.2 пунктээр, 2010 оныхоос 12.6 пунктээр, 2012 оныхоос 9.8 пунктээр, 2013 оныхоос 22.8 пунктээр, 2014 оныхоос 19.6 пунктээр, 2016 оныхоос 12.4 пунктээр буурсан 2017 оныхоос 0.8 пунктээр буурсан байна.

Хянасан: Статистикийн хэлтсийн дарга О.Түмэнжаргал

Танилцуулгыг бэлтгэж боловсруулсан:

Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Должинсүрэн

Харилцах хаяг: Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон, 403 тоот, утас 70323442

Имэйл: uvurkhangai@nso.mn, вэб хаяг: <http://uvurkhangai.nso.mn>